



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

"Сэлэнгэ Барилга захиалагч" ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/24/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: Ц.Ундраа Утас: 70363047 Цахим хаяг: undraats@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

Агуулга

1. Аудитын санал, дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.1 Байгууллагын үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	11
3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	12
4. Аудитын тайлан	13
4.1. Ерөнхий зүйл	13
4.2. Материаллаг байдал	14
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.3.1 Шилэн дансны мэдээлэл	14
4.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудитын талаар	15
4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. Аудитын илрүүлэлт	15
5.1 Залруулга	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	15



“СЭЛЭНГЭ БАРИЛГА ЗАХИАЛАГЧ”
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА Б.МӨНХБАТ ТАНАА

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.03.14 № СЭА-2024/24-НА-СТА-ОНА
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

“Сэлэнгэ Барилга захиалагч” ОНӨААТҮГ нь тайлант онд 268,454.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 125,410.7 мянган төгрөгийн зардал гарган 141,592.5 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Аудитын гол асуудал

Тус үйлдвэрийн газар нь түрээсийн зардлын төлөвлөгөөг 1,500.0 мянган төгрөгөөр баталсан боловч төлөвлөгдөөгүй GPS -тэй геодезийн иж бүрэн багажийг түрээсэлснээс шалтгаалан гүйцэтгэлээр 5,500.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

“Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын 2023 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 2 зорилтын хүрээнд 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 93.3 хувийн хэрэгжилттэйгээр тайлагнасан байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	1/1/2023	12/31/2023
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	226,444,279.29	376,667,471.10
1.1.2	Дансны авлага	18,657,365.56	10,653,148.48
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага		
1.1.6	Бараа материал	3,194,456.85	2,358,418.16
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
	Эргэлтийн хөрөнгийн дүн	248,296,101.70	389,689037.74
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	28,927,365.82	24,519,798.84
1.2.2	Биет бус хөрөнгө		
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	28,927,365.82	24,519,798.84
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	277,223,467.52	414,198,836.58
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1.1.1	Дансны өглөг	4,878,472.99	
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	14,021,724.17	14,283,018.07
2.1.1.4	НДШ-ийн өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.12			
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	18,900,197.16	14,283,018.07
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	18,900,197.16	14,283,018.07
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	258,323,270.36	399,915,818.51
2.3.11	Эздийн өмчийн дүн	258,323,270.36	399,915,818.51
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	277,223,467.52	414,198,836.58

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12 сарын 31	2022 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	198,146,974.55	268,454,544.55
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг(алдагдал)	198,146,974.55	268,454,544.55
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого		
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	31,818.18	
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	79,693,851.64	125,352,403.73
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	5,201,573.00	58,288.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	113,283,368.09	143,043,852.82
19	Орлогын татварын зардал	1,184,849.41	1,451,304.67
20	Татварын дараах ашиг (алдагдал)	112,098,518.68	141,592,548.15
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	112,098,518.68	141,592,548.15
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	112,098,518.68	141,592,548.15
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
8	2022 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл					258,323,270.36	258,323,270.36
	8.1 өмнөх үлдэгдэл					258,323,300.00	258,323,300.00
	8.2 Зөрүү					-29.64	-29.64
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					141,592,548.15	141,592,548.15
10	Залруулсан үлдэгдэл					399,915,818.51	399,915,818.51
11	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					141,592,548.15	141,592,548.15
12	Бусад дэлгэрэнгүй орлого					-141,592,548.15	-141,592,548.15
13	Өмчид гарсан өөрчлөлт						-
14	Зарласан ногдол ашиг						-
15	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						-
16	2023 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	-	-	-	-	399,915,818.51	399,915,818.51

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2021 оны 12 сарын 31	2022 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	211,623,244.00	306,452,491.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	210,636,387.00	303,293,644.00
1.1.2	Бусад мөнгөн орлого	986,857.00	3,158,847.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	80,252,682.57	156,229,299.19
1.2.1	Ажиллагчдад төлсөн	42,325,582.00	64,682,513.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	11,674,722.76	17,509,613.78
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	3,944,850.00	6,435,450.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	1,714,800.00	6,434,800.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	10,835,050.00	12,402,147.00
1.2.6	Даатгалын төлбөрт төлсөн	74,250.00	74,250.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	5,933,470.81	30,370,591.41
1.2.8	Бусад мөнгөн зарлага	3,749,957.00	18,319,934.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	131,370,561.43	150,223,191.81
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Хүлээн авсан хүүний орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	31,461,900.00	
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	31,461,900.00	
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(31,461,900.00)	
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	99,908,661.43	150,223,191.81
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	126,535,617.86	226,444,279.29
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	226,444,279.29	376,667,471.10

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Төсөв/ төгрөгөөр/	Гүйцэтгэл / төгрөгөөр/	Зөрүү	Хувь
1	Нийт орлого/ НӨАТ-гүй/	155,696,263.00	268,454,544.55	-112,758,281.55	172
2	Нийт зарлагын дүн	155,696,263.00	125,410,691.73	30,285,571.27	81
	Цалин хөлс	69,000,000.00	69,753,965.92	-753,965.92	101
3	Үндсэн цалин	65,000,000.00	67,718,516	-2,718,515.92	104
	Урамшуулал цалин	4,000,000.00	2,035,450	1,964,550.00	51
4	НДШ-ийн зардал	8,500,000.00	9,118,971.81	-618,971.81	107
	Бараа үйлчилгээний зардал	78,196,263.00	46,479,466.00	31,716,797.00	59
	Программ хангамжийн зардал	1,000,000.00	308,000	692,000.00	31
	Түлш шатахуун	15,800,000.00	12,402,147	3,397,853.00	78
	Албан томилолт	8,000,000.00	4,880,000	3,120,000.00	61
	Сэлбэг хэрэгсэл	5,500,000.00	2,360,000	3,140,000.00	43
	Шуудан холбоо	1,500,000.00	514,800	985,200.00	34
	Бичиг хэрэг	8,096,263.00	3,340,900	4,755,363.00	41
	Сургалт	5,000,000.00		5,000,000.00	
5	Нэг удаагийн тэтгэмж	1,500,000.00		1,500,000.00	
	Түрээсийн зардал	1,500,000.00	5,560,000	-4,060,000.00	371
	Даатгалын зардал	100,000.00	74,250	25,750.00	74
	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	91,732	8,268.00	92
	Эд хогшил, тоног төхөөрөмжийн	15,000,000.00		15,000,000.00	
	Ашиглалтын зардал			0.00	
	Үйл ажиллагааны бусад зардал	5,000,000.00	572,450	4,427,550.00	11
	Үйл ажиллагааны бус бусад зардал	3,500,000.00	271,200	3,228,800.00	8
	Аудитын төлбөр	600,000.00		600,000.00	
	Аймгийн ЗДТГ-т гэрээний дагуу	6,000,000.00	16,103,987	-10,103,987.00	268
6	Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал		143,043,852.82	-143,043,852.82	
7	Орлогын албан татвар		1,451,304.67	-1,451,304.67	
8	Татварын дараах ашиг, алдагдал		141,592,548.15	-141,592,548.15	
	Нийт ажиллагсдын тоо	6	6	0.00	100
	Удирдах ажилтан	1	1	0.00	100

Гүйцэтгэх ажилтан	1	1	0.00	100
ИТА	3	3	0.00	100
Гэрээт инженер	1	1	0.00	100

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Сэлэнгэ Барилга захиалагч” ОНӨААТҮГ нь “Улсын болон аймаг, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаад дотоодын хөрөнгө оруулалт, зээл тусламжаар хийгдэж буй барилга угсралт, шинэчлэлт, засвар тохижилтын ажилд захиалагчийн хяналт гүйцэтгэх” гэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

“Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Бүтээн байгуулалт, барилгын ажлын төсөв, санхүүг зөв зохистой төлөвлөн зарцуулах,
- Улсын болон орон нутгийн төсвийн, хувийн хөрөнгө оруулалт, төрийн оролцоотой хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр хийгдэх барилга, зам, инженерийн шугам сүлжээний угсралт, ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөө боловсруулах, зураг төсөл зохиох ажлын захиалагчийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Тус үйлдвэрийн газрын үүсгэн байгуулагч нь Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал буюу төлөөлөн хэрэгжүүлэгч нь аймгийн Засаг дарга байх бөгөөд 100 хувь орон нутгийн өмчтэй аж ахуйн нэгж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

“Сэлэнгэ Барилга захиалагч” ОНӨААТҮГ нь аймгийн ИТХ-ын 2014 оны 11 дүгээр тогтоолоор байгуулагдсан байна. Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-д “Аймаг, сум, нийслэл, дүүрэг нь хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулж болно”, 21 дүгээр зүйл “Аймгийн чиг үүрэг”, 21 дүгээр зүйлийн 21.1.2 дахь “аймгийн өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт, түүнд тавих хяналт”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2: “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй:... 4/ “орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих” гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд өөрчлөлт орсон,

- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд өөрчлөлт орсон,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд өөрчлөлт орсон.

Сэлэнгэ Барилга захиалагч ОНӨААТҮГ-ын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт шалгалт хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэлэнгэ Барилга захиалагч ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц гэж үнэлсэн.

Тайлант онд Сэлэнгэ аймгийн Засаг Даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөж ажилласан байна.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

“Сэлэнгэ Барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	226,444.28	376,667.47	150,223.19
Авлага	18,657.37	10,653.15	8,004.22

Бараа материал	3,194.46	2,358.42	836.04
Үндсэн хөрөнгө	28,927.37	24,519.80	4,407.57
Нийт хөрөнгийн дүн	277,223.47	414,198.84	136,975.37
Өр төлбөр	18,900.20	14,283.02	4,617.18
Эздийн өмч	258,323.27	399,915.82	141,592.55
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	277,223.47	414,198.84	136,975.37

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 150,223.19 мянган төгрөгөөр өссөн нь 306,452.49 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 156,229.30 мянган төгрөгийг зарцуулсантай холбоотой байна.

Дансны авлага 10,653.2 мянган төгрөг болж 8,004.2 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь дараах ажил, гүйлгээнээс шалтгаалсан байна.

- Камер суурилуулалтын ажил /Сүхбаатар сум, 7-р баг/ 1,359.4 мянган төгрөгөөр,
- Түшиг сумын эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөлийн их засвар 3,635.5 мянган төгрөгөөр,
- Орхон сумын зам засвар, тэмдэг тэмдэглэгээ, гэрэлтүүлэг 538.8 мянган төгрөгөөр,
- Рашаант тосгоны зам засвар, тэмдэг тэмдэглэгээ, гэрэлтүүлэг 630.7 мянган төгрөгөөр,
- Зам засвар, тэмдэг тэмдэглэгээ, гэрэлтүүлгийн ажил 672.8 мянган төгрөгөөр,
- Баруун бүрэн сумын төрийн албан хаагчийн 4 айлын орон сууц 4,656.42 мянган төгрөгөөр,
- Сант сумын хогийн цэгийн хашаа барих, тохижилтын ажлын захиалагчийн хяналтын зардал 469.7 мянган төгрөгөөр тус тус буурч,
- Баруунбүрэн сумын наадмын талбай засварлах ажлын 3,959.1 мянган төгрөгийн, Хушаат сумын 4,719.6 мянган төгрөгөөр авлага тус тус нэмэгдсэнээс,

Бараа материалын дансны үлдэгдэл 2,358.42 мянган төгрөг байгаа нь байгууллагын хөрөнгөөр 15,021.90 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 15,857.94 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 24,519.8 мянган төгрөг болж 4,407.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлан оны элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 14,283.0 мянган төгрөг болж 4,617.2 мянган төгрөгөөр буурсан нь ХХОАТ-ын өглөг 1,260.3 мянган төгрөгөөр, ААНОАТ-ын өглөг 387.6 мянган төгрөгөөр нэмэгдэж, аймгийн ЗДТГ-т өгөх өглөг 4,846.5 мянган төгрөгөөр, НӨАТ-ын өглөг 1,418.6 мянган төгрөгөөр тус тус буурснаас голлон шалтгаалжээ.

3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу “Сэлэнгэ Барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

“Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Сэлэнгэ аймгийн Засаг дарга баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 155,696.3 мянган төгрөгөөр, нийт зардлыг 155,696.3 мянган төгрөгөөр тогтоосон бөгөөд гүйцэтгэлээр 268,454.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 125,410.7 мянган төгрөгийн зардал гарган, 1,451.3 мянган төгрөгийн орлогын албан татвар тооцож, 141,592.5 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогын гүйцэтгэл 268,454.5 мянган төгрөг болж төлөвлөснөөс 112,758.2 мянган төгрөг буюу 172.4 хувиар давж биелсэн нь аймгийн болон сумдын орон нутгийн хөгжлийн сан, замын сангийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй зам засвар, тэмдэг тэмдэглэгээ, гэрэлтүүлэг болон барилгын гүйцэтгэлд гэрээний үндсэн дээр захиалагчийн хяналтыг гүйцэтгэснээс голлон шалтгаалсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 125,410.7 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 30,285.6 мянган төгрөгөөр буюу 19.5 хувиар хэмнэгдсэн нь шатахуун, албан томилолт, сэлбэг хэрэгслийн эд хогшил, тоног төхөөрөмж, сургалт, нэг удаагийн тэтгэмж, бусад зардлуудыг хэмнэснээс шалтгаалсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. Аудитын тайлан

4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Сэлэнгэ Барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Ундраа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Сэлэнгэ Барилга захиалагч” ОНӨААТҮГ нь 2023 оны санхүүгийн тайлангаа Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 15 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого 198,146.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 1,981.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.3.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлд тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Тайлант хугацаанд “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ нь мэдээлбэл зохих 20 төрлийн 157 мэдээллийг хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

“Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ нь дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Албан хэрэг хөтлөлтийг цахим хэлбэрт шилжүүлж бичиг хэргийн зардлыг хэмнэсэн,
- Албан конторын их засварын ажлыг хийгээгүй,
- Тавилга эд хогшил, тоног төхөөрөмж худалдаж аваагүй
- Шинэ жил болон бусад баяр ёслолд зардал гаргалгүйгээр тус тус зардлыг хэмнэн ажилсан байна.

4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 124 дүгээр “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайланд шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж	1		1		100.0
Нийт дүн	1		1		100.0

4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

5. Аудитын илрүүлэлт

5.1 Залруулга

Аудитаар нийт 141,592.5 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Өмчийн өөрчлөлтийн тайлангийн тайлант үеийн цэвэр ашиг тайлагнаагүй, Аудитаар зөрчил илрээгүй болно.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Өмчийн өөрчлөлтийн тайлангийн тайлант	1	141,592.5			1	141,592.5	1	141,592.5				

"Сэлэнгэ Барилга захиалагч" ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

үеийн цэвэр ашиг тайлагнаагүй													
Нийт дүн	1	141,592.5			1	141,592.5	1	141,592.5					

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс /мянган төгрөгөөр/										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Дүн													

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс /мянган төгрөгөөр/							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Дүн										
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Дүн										
Нийт дүн										